

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хашаат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/119/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: <a href="mailto:Baigalmaat@audit.gov.mn">Baigalmaat@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: <a href="mailto:Nerguibaatar@audit.gov.mn">Nerguibaatar@audit.gov.mn</a> Аудитыг гүйцэтгэсэн: Грут финанс Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж Утас: 77721628 Цахим хаяг: <a href="mailto:Byambadorj@growthfinance.mn">Byambadorj@growthfinance.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 89  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАШААТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ М.МӨНХЧУЛУУН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хашаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,928,298.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 2,635,695.2 мянган төгрөг зарцуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 77 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Боловсролын газраас 93.5 хувьтай үнэлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Данс код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>428,058,250.14</b>	<b>298,355,430.05</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	361,087,199.53	225,932,831.54
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	361,087,199.53	225,932,831.54
31211	Төрийн сангийн харилцах	361,087,199.53	225,932,831.54
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,527,690.60	2,527,690.60
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,527,690.60	2,527,690.60
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>64,443,360.01</b>	<b>69,894,907.91</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>3,808,872.10</b>	<b>5,215,862.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	2,343,872.10	3,689,962.00
35130	Эм боох материал	1,465,000.00	1,525,900.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	962,076.00	693,424.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>59,672,411.91</b>	<b>63,985,621.91</b>
35410	Бичиг хэргийн материал	22,440,561.91	24,068,161.91
35420	Аж ахуйн материал	30,679,300.00	34,609,150.00
35440	Түлш, шатах тослох материал	120,000.00	-
35450	Барилгын засварын материал	4,938,500.00	834,100.00
35460	Хүнсний материал	1,494,050.00	4,474,210.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,840,981,627.78</b>	<b>3,571,248,736.57</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,840,981,627.78	3,571,248,736.57
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,797,235,627.78	3,526,312,736.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,760,621,748.53	3,440,621,928.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(334,903,163.53)	(391,146,298.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,500,000.00	3,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,625,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	324,983,429.00	349,094,069.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(133,783,404.57)	(107,483,428.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	238,408,817.11	262,880,855.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	(88,490,072.21)	(68,052,617.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,917,300.00	20,885,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,797,910.01)	(3,681,356.73)
39217	Ном	19,403,883.46	19,694,283.46
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	43,746,000.00	44,936,000.00
39301	Програм хангамж	3,000,000.00	4,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(10,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,746,000.00	40,746,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,269,039,877.92</b>	<b>3,869,604,166.62</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>22,500.00</b>	<b>7,747,262.44</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	22,500.00	7,747,262.44
<b>413</b>	<b>Өглөг</b>	22,500.00	7,747,262.44
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,912,362.44
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	22,500.00	2,834,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	22,500.00	2,834,900.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,269,017,377.92</b>	<b>3,861,856,904.18</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,269,017,377.92	3,861,856,904.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,608,063,015.44	1,608,063,015.44
512	Хуримтлагдсан үр дүн	1,236,564,575.57	1,829,567,561.83
51210	Өмнөх үеийн үр дүн	1,236,564,575.57	1,236,728,035.57
51220	Тайлант үеийн үр дүн	-	592,839,526.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	424,389,786.91	424,226,326.91
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,269,039,877.92</b>	<b>3,869,604,166.62</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,320,679,760.63</b>	<b>3,378,690,465.17</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>114,680,060.63</b>	<b>813,195,665.17</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	114,680,060.63	813,195,665.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	114,680,060.63	754,041,279.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,605,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	111,276,688.53	748,962,140.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,658,372.10	4,974,139.90
120009	Бусад орлого	-	59,154,385.27
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,205,999,700.00</b>	<b>2,565,494,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,135,167,300.00	2,222,316,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,135,167,300.00	2,222,316,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	70,832,400.00	343,178,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,832,400.00	343,178,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,102,996,665.20</b>	<b>2,785,691,338.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,102,996,665.20</b>	<b>2,785,691,338.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,038,139,929.81	2,630,935,866.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,462,923,632.53	1,745,642,924.72
210101	Үндсэн цалин	990,112,491.31	1,113,393,690.63
210102	Нэмэгдэл	408,650,691.22	540,714,235.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,950,000.00
210104	Урамшуулал	64,160,450.00	84,584,998.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	179,437,149.10	214,353,264.30
210201	Тэтгэврийн даатгал	123,154,313.97	147,064,668.65
210202	Тэтгэмжийн даатгал	14,701,741.21	18,399,583.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,628,434.69	9,127,191.73
210204	Ажилгүйдлийн даатгал	7,159,287.96	8,926,133.76
210205	Эрүүл мэндийн даатгал	26,793,371.27	30,835,686.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	62,771,026.61	274,692,124.44
210301	Гэрэл, цахилгаан	16,380,816.61	21,208,208.60
210302	Түлш, халаалт	45,701,250.00	253,278,075.84
210303	Цэвэр, бохир ус	688,960.00	205,840.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	125,324,420.00	181,592,790.00
210502	Хоол, хүнс	125,324,420.00	181,592,790.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,993,500.00	7,724,400.00
210604	Урсгал засвар	4,993,500.00	7,724,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	25,299,768.22	35,551,128.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,605,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,694,768.22	35,551,128.97
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	177,390,433.35	171,379,234.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,554,552.00	37,899,318.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,287,893.14	9,450,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	113,547,988.21	124,029,816.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	64,856,735.39	154,755,472.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	62,425,612.00	89,696,472.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,803,212.00	81,664,372.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,622,400.00	8,032,100.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	2,431,123.39	65,059,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,431,123.39	65,059,000.00

**Архангай аймгийн Хашаат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>217,683,095.43</b>	<b>592,999,126.26</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	32,519,928.78	159,600.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	32,519,928.78	159,600.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(32,519,928.78)	(159,600.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>185,163,166.65</b>	<b>592,839,526.26</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,207,744,700.00</b>	<b>2,565,599,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,745,000.00</b>	<b>105,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,745,000.00</b>	<b>105,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,745,000.00</b>	<b>105,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,605,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,205,999,700.00</b>	<b>2,565,494,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,135,167,300.00	2,222,316,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,135,167,300.00	2,222,316,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>70,832,400.00</b>	<b>343,178,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,832,400.00	343,178,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,999,818,283.85</b>	<b>2,654,359,167.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,999,818,283.85</b>	<b>2,654,359,167.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,935,533,430.46</b>	<b>2,499,872,347.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,462,923,632.53</b>	<b>1,745,642,924.72</b>
210101	Үндсэн цалин	990,112,491.31	1,113,393,690.63
210102	Нэмэгдэл	408,650,691.22	540,714,235.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,950,000.00
210104	Урамшуулал	64,160,450.00	84,584,998.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>179,437,149.10</b>	<b>214,353,264.30</b>
210201	Тэтгэврийн даатгал	123,154,313.97	147,064,668.65
210202	Тэтгэмжийн даатгал	14,701,741.21	18,399,583.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,628,434.69	9,127,191.73
210204	Ажилгүйдлийн даатгал	7,159,287.96	8,926,133.76
210205	Эрүүл мэндийн даатгал	26,793,371.27	30,835,686.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,284,276.61</b>	<b>274,499,700.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,672,956.39	21,078,578.66
210302	Түлш, халаалт	45,569,796.14	252,965,681.34
210303	Цэвэр, бохир ус	1,041,524.08	455,440.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>126,824,202.00</b>	<b>184,572,950.00</b>
210502	Хоол, хүнс	126,824,202.00	184,572,950.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,117,000.00</b>	<b>3,620,000.00</b>
210604	Урсгал засвар	6,117,000.00	3,620,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>25,299,768.22</b>	<b>31,967,378.97</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,605,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,694,768.22	31,967,378.97
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>72,647,402.00</b>	<b>45,216,130.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,712,102.00	36,875,780.00

Архангай аймгийн Хашаат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,935,300.00	8,340,350.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>64,284,853.39</b>	<b>154,486,820.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>61,853,730.00</b>	<b>89,427,820.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,231,330.00	81,395,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,622,400.00	8,032,100.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,431,123.39</b>	<b>65,059,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,431,123.39	65,059,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>207,926,416.15</b>	<b>(88,759,367.99)</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>26,277,500.00</b>	<b>46,395,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,277,500.00</b>	<b>46,395,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>26,277,500.00</b>	<b>46,395,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	26,277,500.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	46,395,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(26,277,500.00)</b>	<b>(46,395,000.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	181,648,916.15	(135,154,367.99)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>179,438,283.38</b>	<b>361,087,199.53</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>361,087,199.53</b>	<b>225,932,831.54</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр )

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,608,063,015.44</b>	<b>424,389,786.91</b>	<b>1,236,564,575.57</b>	<b>3,086,072,141.27</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	163,460.00	
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,608,063,015.44</b>	<b>424,389,786.91</b>	<b>1,236,728,035.57</b>	<b>3,086,072,141.27</b>
Тайлант үеийн үр дүн	-	-		182,945,236.65
<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,608,063,015.44</b>	<b>424,389,786.91</b>	<b>1,236,728,035.57</b>	<b>3,269,017,377.92</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(163,460.00)	-	(163,460.00)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,608,063,015.44</b>	<b>424,226,326.91</b>	<b>1,236,728,035.57</b>	<b>3,269,017,377.92</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	592,839,526.26	592,839,526.26
<b>2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,608,063,015.44</b>	<b>424,226,326.91</b>	<b>1,829,567,561.83</b>	<b>3,861,856,904.18</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр )

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,928,298,200.00	2,635,695,167.99	292,603,032.01	90.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,928,298,200.00	2,635,695,167.99	292,603,032.01	90.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,835,790,000.00	2,546,267,347.99	289,522,652.01	89.8
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,985,768,000.00	1,745,642,924.72	240,125,075.28	87.9
210101	Үндсэн цалин	1,242,318,800.00	1,113,393,690.63	128,925,109.37	89.6
210102	Нэмэгдэл	694,599,600.00	540,714,235.69	153,885,364.31	77.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,950,000.00	(6,950,000.00)	-
210104	Урамшуулал	48,849,600.00	84,584,998.40	(35,735,398.40)	173.2
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	248,698,800.00	214,353,264.30	34,345,535.70	86.2
210201	Тэтгэврийн даатгал	169,115,300.00	147,064,668.65	22,050,631.35	87.0
210202	Тэтгэмжийн даатгал	19,895,900.00	18,399,583.34	1,496,316.66	92.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,947,900.00	9,127,191.73	820,708.27	91.7
210204	Ажилгүйдлийн даатгал	9,947,900.00	8,926,133.76	1,021,766.24	89.7
210205	Эрүүл мэндийн даатгал	39,791,800.00	30,835,686.82	8,956,113.18	77.5
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	274,499,700.00	274,499,700.00	(0.00)	100.0
210301	Гэрэл, цахилгаан	19,574,900.00	21,078,578.66	(1,503,678.66)	107.7
210302	Түлш, халаалт	253,184,800.00	252,965,681.34	219,118.66	99.9
210303	Цэвэр, бохир ус	1,740,000.00	455,440.00	1,284,560.00	26.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	-	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	197,599,800.00	184,572,950.00	13,026,850.00	93.4
210502	Хоол, хүнс	197,599,800.00	184,572,950.00	13,026,850.00	93.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,620,000.00	3,620,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,620,000.00	3,620,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	32,513,400.00	31,967,378.97	546,021.03	98.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,513,400.00	31,967,378.97	546,021.03	98.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	93,090,300.00	91,611,130.00	1,479,170.00	98.4

Архангай аймгийн Хашаат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,997,000.00	82,195,780.00	801,220.00	99.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,093,300.00	9,415,350.00	677,950.00	93.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>92,508,200.00</b>	<b>89,427,820.00</b>	<b>3,080,380.00</b>	<b>96.7</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>92,508,200.00</b>	<b>89,427,820.00</b>	<b>3,080,380.00</b>	<b>96.7</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	84,476,100.00	81,395,720.00	3,080,380.00	96.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,032,100.00	8,032,100.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,928,403,200.00</b>	<b>2,500,540,800.00</b>	<b>427,862,400.00</b>	<b>85.4</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,294,985,800.00</b>	<b>2,222,316,100.00</b>	<b>72,669,700.00</b>	<b>96.8</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,294,985,800.00	2,222,316,100.00	72,669,700.00	96.8
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>278,119,700.00</b>	<b>278,119,700.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	278,119,700.00	278,119,700.00	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>355,297,700.00</b>	<b>105,000.00</b>	<b>355,192,700.00</b>	<b>0.0</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	105,000.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	355,192,700.00	-	355,192,700.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>361,087,199.53</b>	<b>361,087,199.53</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>361,192,199.53</b>	<b>225,932,831.54</b>	<b>135,259,367.99</b>	<b>-</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>66.0</b>	<b>66.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	3.0	3.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	37.0	37.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	26.0	26.0	-	100.0
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>549.0</b>	<b>549.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>549.0</b>	<b>549.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
630001	Төрийн өмчит ЕБС	549.0	549.0	-	100.0

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 4,654.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 155.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 4,498.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 4,654.4 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 31,297.7 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

3.1.1. Архангай аймгийн Боловсролын газрын даргын Б/21, А/45 тоот тушаалаар ур чадварын нэмэгдлийг тайлант жилийн 3–6, 9–12 дугаар саруудад олгосон бол 8 дугаар сард тушаалгүйгээр захиралд 155.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь "Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 ".харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх" мөн "ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2 "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 3.2 Албан шаардлага

3.2.1. "Балансын урамшуулал олгох тухай" тус сургуулийн захирлын 2025.09.24-ний өдрийн Б/33 дугаар тушаалыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2.2 Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалд 8,032.1 мянган төгрөгийг 67 ажилтанд олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь болох 803.2 мянган төгрөгийг суутгасан байх бөгөөд 1,834.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган авч, төсөвт төлөөгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна": 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

### 3.3 Зөвлөмж

3.3.1 Ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа харилцагч бүрээр тооцоо үүсгэн бүртгээгүй, мөн нэг харилцагчийг өөр өөр нэршлээр бүртгэсэн зөрчил илэрсэн. Үүний улмаас санхүүгийн тайланд тусгагдсан өр, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т " үнэн зөв байх" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа харилцагч бүрээр тооцоо үүсгэж бүртгэх, харилцагчийн бүртгэлийг нэг код, нэг нэршлээр стандартчилж давхардлыг арилган, үлдэгдлийг тулган баталгаажуулж засварын бичилт хийж, цаашид дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдэл илүү олгосон	1	155.9	1	155.9				
Балансын урамшуулал олгосон	1	2,664.0			1	2,664.0		
НДШ суутган буюу ногдуулаагүй.	1	1,834.5			1	1,834.5		
Өр төлбөрийн харилцагч үүсгэх.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>4,654.4</b>	<b>1</b>	<b>155.9</b>	<b>2</b>	<b>4,498.5</b>	<b>1</b>	<b>-</b>